



Намын Удирдах Зөвлөлийн 2000 оны 04-р сарын 24-ны өдрийн хурлаар хэлэлцэж батлав.

Монголын Иргэний Ардчилсан Шинэ Либерал Намаас Монгол Улсын Их Хурлын 2000 оны сонгуульд оролцөх хөтөлбөр

" Монгол Улсын Иргэн - Монгол улсын Эзэн " гэсэн уриан дор оролцоно.

ЭРХЭМ ЗОРИЛГО

Монгол улсын тусгаар тогтол, монгол хүний өвөг дээдсийн уламжлалт зан үйл, ёс заншлыг дээдлэн шинэтгэн улс орноо хүн төрөлхтний жам ёснызамиаар хөгжүүлэх, өөрийн үзэл санааны иш үндэс болсон шинэ Либерал үзэл баримтлалын дор ардчилал, иргэний эрх чөлөө, чөлөөт хөгжлийг хангах явдлын үүднээс иргэний нэр хүндийг баталгаажуулах, эрхэмлэх, өөрийн орны үндэсний хувь заяа, үндэсний эрх ашгийн тусын тулд өөрийн зорилгоо хэрэгжүүлэхдээ ард түмний язгуур эрх ашиг үнэт зүйлсийн үнэлэмжийг дахин үнэлэх, хүнийг хөгжүүлэх Плебисттөр ардчилал ба хуулийг олон түмнээр хэлэлцүүлэх, нутгийн өөрөө удирдах ёсыг бэхжүүлэх иргэний ардчилсан нийгмийн чиг баримжаат төрийг байгуулах үзэл бодол тус намын бодлого мөн.

Иргэн бүр амьдралын бүхий л хүрээнд эрхээ хууль ёсоор эдэлж, иргэний ардчилсан уламжлалт ёс зүйг нийгмийн амьдралд хөгжлийн жам ёсны гольдролд оруулснаар улс орны нийгмийн тогтолцоог төлөвшүүлж, үндэсний язгуур эрх ашиг, аюулгүй байдлыг хамгаалахад оршино.

Үүний тулд:

Үйл ажиллагааны зорилт:

Иргэний өмч, хөдөлмөр

Иргэний боловсрол, мэргэжил

Иргэний эрх үүрэг

Иргэний эрүүл мэнд

Үндэсний язгуур эрх ашиг , аюулгүй байдлыг хамгаалахад чиглэнэ.

1. Улс төрийн талаар

МИАШЛНЫН иргэний эрх ашиг, төрийн бодлогын гол зорилт нь хүн төрөлхтний үнэт зүйлс болох хүний эрх, эрх чөлөөг дээдлэн, өнөөгийн Үндсэн хуулинд заасан эрх зүйн төрийг төлөвшүүлэх, улмаар цаашдаа нийгмийн чиг баримжаат төрийг тогтоох нөхцөл боломжийг бүрдүүлэхэд чиглэнэ.

- Монгол Улсын төрийн бодлогын нэгдсэн үзэл баримтлалыг бий болгож хэрэгжүүлэхийн төлөө чармайн ажиллаж төр төвтэй удирдлагын тогтолцоог бүрдүүлнэ..

- Монголын төрийн удирдлагад арчилалыг бодитой хэрэгжүүлэх механизмыг бүрдүүлж, төр иргэн харилцан үүрэг хариуцлага хүлээдэг зарчмыг тууштай хэрэгжүүлэхийн төлөө тэмцэж хүнд суртлын тогтолцоог хална.
- Төрийн зүгээс боловсон хүчний бодлогыг уламжлал шинэчлэлийн үндсэнд боловсруулж хэрэгжүүлэх, төрийн албан хаагчдын ёс зүйг дээшлүүлэх тууштай арга хэмжээ авч, төрийн менежментийг сайжруулна..
- Төрийн дээд байгууллагуудын уялдаа холбоог сайжруулж, хууль хяналтын байгууллагын бүтэц, үйл ажиллагааг өргөжүүлж, хууль ёсыг чандлан сахиулахын төлөө туйлбартай тэмцэж, яам, тусгай газар, агентлагуудыг цөөлж бүтцэд нь шинэтгэл хийнэ.

2. Эдийн засгийн талаар

- Үндэсний үйлдвэрлэлийг дэмжих замаар эдийн засгийг тэнцвэртэй хөгжүүлэх эрх зүйн орчинг бүрдүүлнэ.
- Татварын хууль тогтоомжийг эдийн засгийн бодлогын дагуу шинэчилж албан татварын ачааллыг шударга хуваарилж , татвар төлөгчдийн ашиг сонирхлыг хамгаалах эрх зүйн орчинг бүрдүүлнэ.
- Монгол Улсын иргэдийн нийгэм улс төр, эдийн засаг, хувийн эрхийг бүхий л хүрээнд хамгаалж, өөрийгөө бүх талаар хөгжүүлэх нөхцөл, боломжийг бий болгосноор идэвхтэй амьдрах чадварт иргэнийг төлөвшүүлэхийн төлөө ажиллана.
- Монгол Улсын хүн амын амьжиргааны түвшинг дээшлүүлэх, эдийн засаг, нийгэм хангамж, эрх зүйн орчинг бүрдүүлнэ.
- Салбарын хөгжлийн онцлогийг өмчийн бүх хэлбэртэй хослуулах
- Экспортын чиглэлийн үйлдвэрлэлийг дэмжих замаар тулгарч буй асуудлыг шийдвэрлэх.
- Импортын талаар хатуу бодлого баримталж улсын валютын нөөцийг арвижуулах.
- Үндэсний үйлдвэрлэлийг дэмжихэд суурь үнийг бууруулах талаар тууштай арга хэмжээ авч хэрэгжүүлнэ.
- Иргэний болон ерх гэрийн орлого нэмэгдүүлэх, тэдний хуримтлалыг нэмэгдүүлэхийн тулд иргэн бүрийг ажилд хамруулах, ажлын байр бий болгох.
- Малыг төрийн хамгаалалтад бүрэн утгаар нь байлгахын тулд аюулгүйн санг байгуулна.
- Үндэсний үйлдвэрлэл хөгжих нөхцлийг хангасан дэд бүтцийг төрийн өмчийн чиглэлээр хөгжүүлж ажилгүйдлийг бууруулан, 50 мянгаас доошгүй ажлын байр бий болгоно.
- Банкны зээлийн 50-с доошгүй хувийг үндэсний үйлдвэрлэлийн үндсэн ба эргэлтийн хөрөнгийг санхүүжүүлэхэд зориулна.
- Хот суурингийн хилээс гаднах газрыг үл хувьчилна.

Харилцааны мөнежментийг боловсронгуй болгох арга хэмжээ авч хөдөлмөрийн хүний ажил эрхлэх эрхийг тууштай хамгаална.

Иргэний орон сууцны нөхцлийг сайжруулах, залуу гэр бүлийг орон сууцаар хангах үндэсний хөтөлбөр, хууль боловсруулж, түүнийг хөргэжүүлэх эдийн засаг, санхүүгийн механизмыг бүрдүүлнэ.

Эмнэлэгийн даатгалын тогтолцоог боловсронгуй болгох, эмнэлэг үйлчилгээний чанар, тоног төхөөрмжийн хангамжийг эрс сайжруулах арга хэмжээг төр засгаас нэн яаралтай авах ёстой гэсэн шаардлагыг хатуу баримтлах болно.

Хүнийг хөгжүүлэх явдал улс орны хөгжил дэвшилийн үндсэн баталгаа мөн. Боловсролын тогтолцоог ясли цэцэрлэгээс эхлээд шинжлэх ухааны доктор бэлтгэх хүртлэх бүх шатанд шинэчлэн боловсронгуй болгож голөвшүүлэхийн төлөө тэмцэнэ.

Гадаад бодлогын талаар:

Дэлхийн хамтын нийгэмлэг, улс орнуудтай найрсаг, тэгш, харилцан ашигтай хамтран ажиллан бие даан хөгжине.

МИАШЛН гадаад орын ардчилсан ёс, нийгмийн дэвшилийн баримжаатай намуудтай олон талын үндсэн дэр идэвхитэй харилцааг хөгжүүлнэ.

МИАШЛН-ын мөрийн хөтөлбөр нь намын бодлогын үндсийг тодорхойлж, цаашид улс орны тухайн үеийн хөгжилтэй уялдуулан, үндэснийхээ хийгээд хүн төрөлхтний оюуныүнэт зүйлсийг хослуулан нийгмийнхээ оюун ухааныг баяжуулан эдийн засгаа эрдэм ухаанаар хөгжүүлэх замаар Монгол улсыг биө даан хөгжих хүчин зүйл болох юм.

Нэг хүнд ноогдох гадаад өрийг 20-с дээш хувиар бууруулна.

Өрилго: Улс төрийн шинэ либерал үзлээр чиг баримжаа болгож, иргэдийн ардчилсан идэвхитэй үйл ажиллагаанд тулгуурлан өөрийгөө тэтгэх эдийн засгийн бүтэц бүхий улс орон болох нөхцлийг ойрын 4 жилд бүрдүүлж, сайн тийхан амьжиргааны нийгэм байгуулах үндэс суурийг тавина.

3. Нийгмийн талаар

- МИАШЛН нь иргэнийхээ эрхийг дээдэлснээр аливаа зөрчил, гэмт хэргийн эсрэг шударга тэмцэлд тууштай зогсоно.
- Боловсролын салбарт хөрөнгө оруулалт хийх, дунд боловсролыг үнэ төлбөргүй олгох, олж авбал зохих мэдлэг чадварын стандарт боловсруулж мөрдөх, олон улсын мэдээллийн сүлжээнд найдвартай холбох, сургууль засвардалтыг бүрэн зогсоож, албан бус сургалтын хэлбэрийг хөхүүлэн дэмжиж үр ашигтай ашиглах арга хэмжээг тууштай хэрэгжүүлэхийн төлөө тэмцэнэ.
- Боловсролын чанарыг дээшлүүлэх, тэргүүлэх мэргэжилтэн, авьяаслаг хүмүүсийг онцлон дэмжих, үндэсний бичиг үсгээ сэргээн хэрэглэх бодлогыг тууштай хэрэгжүүлнэ.
- ШУ-ны улс ардын аж ахуйд өгөх үр өгөөжийг дээшлүүлэх, эрдэмтэдийн шинийг бүтээх хүсэл тэмүүлэлэлд бүх талын тусламж үзүүлэх, шинэ төхник төхнологи эзэмших буй болгох явдлыг бүх талаар дэмжиж шинжлэх ухаанд зарцуулах хөрөнгийг ҮНБ-ний 3-аас доошгүй хувьд хүргэхийн төлөө тэмцэнэ.
- Оюун санааны амьдрал ядуурч хоосроогоос сэргийлэхийн тулд үндэсний түүх, соёл, урлаг, сэтгэлгээний давтагдашгүй уламжлалаа хадгалах, сонгодог болон орчин үеийн урлагын шинэ төрөл зүйл, урлаг соёлын бүтээлийг төрөөс хөхүүлэн дэмжих эдийн засгийн хөшүүргийн шинэ механизмыг буй болгох хөтөлбөр дэвшүүлж түүнийгээ хэрэгжүүлэх хууль зүйн орчинг бүрдүүлнэ.
- Иргэдийн чөлөөт завыг зөв өнгөрүүлэх, эрүүл мэндээ өөрийн санаачилгаар хамгаалах нөхцлийг бүрдүүлэх хийгээд монгол хүний авьяас чадвар, хүч чадлын бололцоог дэлхий дахинаа нээн гаргах, боломжийг нэмэгдүүлэх чиглэлээр биеийн тамир спортын байгууллагын бүтэц тогтолцоог төгөлдөржүүлэх, шинжлэх ухаанжуулах, төрөөс дэмждэг иж бүрэн арга хэмжээ авч хэрэгжүүлнэ.
- МИАШЛН-ын нийгмийн бодлогын тулгуур нь иргэдэд төрөөс үзүүлэх үйлчилгээг хүртээмжтэй, ялгаваргүй чанартай байлгахад орших бөгөөд нийгмийн халамжийн иж бүрэн тогтолцоог бүрдүүлэх эрх зүйн орчинг буй болгохын төлөө тэмцэнэ.
- Хүн амын бодит орлогыг 2-оос доошгүй дахин нэмэгдүүлэх, хөдөлмөрийн үнэлэмжийг дээшлүүлэх, цалин хөлс, тэтгэвэр, тэтгэмжийн бүсийн нэмэгдэл хөнгөлөлт олгох, иргэдийн хувираа аж ахуй эрхлэх нөхцөл боломжийг сайжруулах зэрэг шат дараалсан арга хэмжээ авна.
- Нийгмийн эмзэг хэсэг, өндөр настан, хүүхэд, тахир дутуу хүмүүс, залуучууд, олон хүүхэдтэй эхчүүд зэрэг нийгмийн тодорхой хэсгүүдэд үзүүлдэг халамж, дэмжлэг туслалцааг нэмэгдүүлж амьжиргааны баталгаат доод түвшинг жилд 400-с доошгүй долларт хүргэхийн төлөө тэмцэнэ. Даатгалын тогтолцоог өргөжүүлэх, хөгжүүлэх арга хэмжээ авна.
- Хөдөлмөр эрхэлж буй хүмүүсийн аюулгүй ажиллах нөхцлийг эрс өөрчлөн сайжруулах, экологийн аюулгүй орчинд ажиллаж амьдрах боломжийг хангахад төр засгийн оролцоо хяналтыг өргөжүүлэхийн төлөө тэмцэнэ. Төрөл бүрийн өмчийн үйлдвэр, аж ахуйн салбарт хөдөлмөрийн